



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянлиг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/10/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: Bayankhongor@audit.gov.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга тэргүүлэх аудитор : Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Д.Цэцэгмаа Утас: Цахим хаяг:</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	4
2. Аудитын тайлан.....	6
2.1. Оршил.....	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	6
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	8
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	9
2.8.3 Авлага.....	9
2.8.4 Урьдчилгаа.....	9
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	9
2.8.6 Бараа материал.....	10
2.8.7 Үндсэн хөрөнгө.....	10
2.8.8 Өр төлбөр.....	10
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	11
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	13
2.11. Шилэн дансны мэдээлэл.....	13
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3. Менежментийн захидал.....	14
3.1. Орлого төвлөрүүлэлттэй холбоотой асуудал.....	14
3.2 .Хөрөнгө, тооллого тооцоо той холбоотой асуудал.....	14

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	17
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	20
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	23
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	24
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	28
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

᠒᠐᠒᠐.᠐3.23 № 4351

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГА Г
А.БАДМААДОРЖ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2.3-д заасны дагуу Баянлиг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянлиг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянлиг сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

• 005020280

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Баянлиг сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баянлиг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч А.Бадмаадорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баянлиг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянлиг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 16-наас 2020 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэв.

Баянлиг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 80 тоот албан бичгээр ирүүлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2020 оны 03 дугаар 05-нд ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баянлиг сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу боловсруулагдсан байна.

Баянлиг сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2019 онд тус сумын дотоод төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хянасан ба хяналт шалгалтаар зөрчил, дутагдал илрээгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянлиг сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4871,6 сая төгрөгийн 1.0 хувь буюу 48,7 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувь буюу 36,3 сая төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн байгууллага 7, тусгайн сан 2, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ, ЭМТ, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Соёлын төв, Бага сургууль, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж санал дүгнэлт өгөөгүй байна.

Аудитад хамрагдаж дүгнэлт гаргасан 4 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Баянлиг сумын ТТЗ-чийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар залруулах алдаа зөрчил илрээгүй .

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

ТТЗ-чийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар акт тогтоогоогүй, албан шаардлага өгөөгүй . Харин харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар нийт 328,9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчил

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд залруулагдаагүй дараах 328,9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ.:/зөрчлийн нэгтгэлийг хавсралтаар харуулсан болно/ Үүнд:

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1.Сумын ЗДТГ	6	258,2	2	3,0	1	250,6	3	4,6
2.ЭМТ	2	0,97	2	0,97				
3.СХС	1	39,15	1	39,15				
4.ЕБС	5	22,6	1	0,2	1	22,4	3	0,00
5.Цэцэрлэг	4	6,5					4	6,5
6.ИТХ	2	0,2					2	0,2
7.Бага сургууль	1	1,26					1	1,26
ДҮН	21	328,88	6	43,32	2	273,0	13	12,56

Сая төгрөгөөр

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 216.0 сая, эцсийн үлдэгдэл 171.9 сая төгрөг болж, 44.1сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө	216,0	171,9	-44,1	100,0

Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
Дүн	216,0	171,9	-44,1	100,0

Эх сурвалж: Баянлиг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 144,2 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн буюу ОНХС-гийн харилцах дансанд 73,8 сая, СХС-гийн харилцах дансанд 70,4 сая, ОНХО-ын дансанд 27,7 сая төгрөг байршиж байна.

ОНХО-ын дансны үлдэгдэл нь оны эхэнд 30,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант хугацаанд ОНО-оор 98,1 с сая төгрөг, санхүүгийн дэмжлэгээр 724,2 сая төгрөг тус тус төвлөрч, 833,8 сая төгрөгийн санхүүжилт олгож, төсөвт байгууллагууд 8,3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, үлдэгдэл 27,7 сая төгрөг байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө, хадгаламжийн дансанд мөнгөн хөрөнгө байхгүй байна.

2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний, эцсийн үлдэгдэл байхгүй.

2.8.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 160,5 сая, эцсийн үлдэгдэл 201,3 сая төгрөг болж 40,8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	11,1	0	-11,1
Ажиллагсадтай холбогдсон авлага	2,2	0,2	-2,0
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	133,4	180,9	47,5
Бусад авлага	13,8	20,2	6,4
Зээлийн авлага			
Дүн	160,5	201,3	40,8

Эх сурвалж: Баянлиг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 201,1 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийг 3 жилийн хугацаатай олгосон зээлийн авлагын үлдэгдэл 180,9 сая төгрөг байгаа ба үүнээс 39.1 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн зээлийн авлага байна.
- ОНХС-гаас малжуулах төслөөр 3 жилийн хугацаатай олгосон зээлийн авлага 20,2 сая төгрөг байгаа нь тул насжилт өндөртэй авлага үүсэхэд нөлөөлж байгаа болно.

2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний, эцсийн үлдэгдэл байхгүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилгаа данстай холбоотой өмнөх онд болон тайлант хугацаанд алдаа, зөрчил илрээгүй.

2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний, эцсийн үлдэгдэл байхгүй.

2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 242,9 сая, эцсийн үлдэгдэл 276,3 сая төгрөг болж, 33,4 төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1.Тусгай зориулалтын материал	21,4	29,1	7,7
2.Эм, ороох боох материал	0,6	4,7	4,1
3.Хангамжийн материал	182,7	208,3	25,6
4.Дуусаагүй үйлдвэрлэл	38,2	34,2	-4,0
Дүн	242,9	276,3	33,4

Эх сурвалж: Баянлиг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд тайлант онд тусгай зориулалтын материал 10,7 сая төгрөгөөр нэмэгдэж, 3,0 сая төгрөгийн зарцуулалт гарч нөөцийг 7,7 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 370,3 сая төгрөгөөр нэмэгдэж, 340,8 сая төгрөгийн зарцуулалт гарч нөөцийг 25,6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй бараа материалын дансанд бүртгэлтэй хөрөнгө байхгүй байна.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 15673,0 сая, эцсийн үлдэгдэл 16013,7 сая төгрөг болж, 340,7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1.Барилга байгууламж	13954,6	14002,7	48,1
2.Тээврийн хэрэгсэл	278,8	372,7	93,9
3.Машин, тоног төхөөрөмж	685,9	764,3	78,4
4.Тавилга, эд хогшил	363,1	431,5	68,4
5.Зам гүүрийн байгууламж байгууламж	7,2	13,6	6,4
6.Номын фонд	34,7	36,0	1,3
7.Бусад үндсэн хөрөнгө	197,5	243,0	45,5
8.Программ хангамж	3,7	3,7	0
9.Бусад биет бус хөрөнгө	147,5	146,2	-1,3
Дүн	15673,0	16013,7	340,7

Эх сурвалж: Баянлиг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 93,7 сая, үнэ төлбөргүй бусад эх үүсвэрээс авсан 382,8 сая төгрөгөөр нэмэгдэж, худалдсан 18,9 сая, акталсан 115,8 сая, бусад 1,1 сая, нийт 135,8 сая төгрөгөөр хасагдсан байна.

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл байхгүй, эцсийн үлдэгдэл 0,03 сая төгрөг болж 0,03 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
----------	-------------------	--------------------	---------------------	--------------------

Богино хугацаат өр төлбөр дүн	0	0,03	0,03	100,0
1.Ажиллагсадтай холбогдсон өглөг	0	0,03	0,03	100,0
Нийт дүн	0	0,03	0,03	100,0

Эх сурвалж: Баянлиг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 14664,5 сая, эцсийн үлдэгдэл 14485,3 сая төгрөг болж, 179,2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/Н бууралт/-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1686,1	1686,1	0	11,6
Өмч /төрийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/				
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/				
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/				
Хуримтлагдсан үр дүн	11891,4	11713,9	-177,5	80,8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1087,0	1085,3	-1,7	7,6
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
Дүн	14664,5	14485,3	-179,2	100,0

Эх сурвалж: Баянлиг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс дүнгээрээ 179,2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн -179,2 сая төгрөгөөр илэрхийлэгдсэнтэй холбоотой байна.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга гараагүй.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын хуралдааны 2018,12,17-ны өдрийн 10/03 тоот тогтоолоор татварын болон татварын бус орлогоор 78,2 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 0,6 сая, нийт 78,8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөгөө батлагдсан. Тайлант жилийн хугацаанд орлогын төлөвлөгөөнд өөрчлөлт ороогүй байна. Гүйцэтгэлээр ОНХО-ын дансанд төвлөрсөн орлогын дүн 98,7 сая, татварын мэдээгээр 97,7 сая төгрөг бөгөөд зөрүү 1.0 сая төгрөг нь оны сүүлийн өдөр 1 иргэний төлсөн татварын 0,9 сая төгрөгийг банк давхардуулан гүйлгээ хийснээс ондоо багтаан залруулга хийгээгүй, ТЕГ-аас хуваарилсан ГНАТ-ын 0,1 сая /53729 төг/- БНА-2020/10/СТА-ТТЗ

ийг татварт мэдээлээгүйгээс зөрүү үүссэн бөгөөд татварын хэлтэст мэдээлсэн дүнгээр тооцож үзэхэд орон нутагт төвлөрүүлэх орлогын татварын орлогын төлөвлөгөө 14,5 сая төгрөгөөр давж биелсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын төрлөөр нь үзвэл ХХОАТ-ын орлогоор 68,0 сая төгрөгийг оруулахаар төлөвлөж 85,2 сая төгрөгийг төвлөрүүлж 17,2 сая төгрөгөөр давж, бусад төлбөр хураамжаас 6,8 сая төгрөг орохоос 4,8 сая төгрөг орж 2,9 сая төгрөгөөр тасарсан байна. ХХОАТ-ын төлөвлөгөө давж биелсэн нь хадгаламжийн хүүгийн орлого өссөн, малчдад төрөөс олгосон ноосны үнийн хөнгөлөлтөөс татвар суутган тооцсонтой холбоотой байна.

Татварын мэдээний зөрүү залруулга 0,9 сая төгрөгийг өглөгөөр тусгахгүйгээр 2020 онд хурлаар батлан буцаан олгохыг СТСХ-ээс чиглэл өгсний дагуу өглөгөөр тусгаагүй байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А. Нийт орлогын дүн	78,8	97,8	19,0	124,1
1.Татварын орлого :	76,2	90,7	14,5	92,7
а/ ХХОАТ	68,0	85,2	17,2	94,0
б/Бууны албан татвар	1,4	1,4	0,00	1,5
в/Бусад татвар, төлбөр хураамж	6,8	3,9	-2,9	4,3
г/Бусад татвар	0,3	0,3	0,00	0,02
2.Татварын бус орлого	2,6	7,1	4,5	7,3
а/Торгуулийн орлого	2,0	6,5	4,5	91,5
б/ Төсөвт байгууллагын өөрийн орлого	0,6	0,6	0,0	8,5

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 3083,2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2855,6 сая төгрөгийг урсгал зардалд, 227,6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Сумын ИТХ-ын хуралдааны 2012.12.17-ны 10/03 тоот тогтоолоор төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээг 3083,2 сая төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг сумын татварын болон татварын бус орлогоор 78,2 сая төгрөг төвлөрүүлэх, аймгийн төсвөөс 724,2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авах, ОНХС-аас 227,0 сая төгрөг, ТЗШ-ээр 1767,1 сая, ЭМД-аас 38,7 сая, сумын төсөвт байгууллагын өөрийн орлогоор 0,6 сая, СХС-гийн зээлийн эргэн төлөлтөөс 52,9 сая, сумын ОНХО-ын эхний үлдэгдлээс 31,8 сая, ОНХС-гийн эхний үлдэгдлээс 52,5 сая, СХС-гийн оны эхний үлдэгдлээс 110,2 сая төгрөгийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төсвийг баталсан байна. Анх баталсан төсөвт аймгийн ИТХ-ын хуралдааны 2019,09,23-ны 17/08, аймгийн Засаг даргын 2019,10,28-ны А/560, 2012,12,16-ны А/645 тоот, сумын Засаг даргын 2019,12,15-ны 105 тоот захирамж, сумын ИТХ-ын даргын 2019,12,23-ны 15 тоот тогтоолоор тус тус өөрчлөлт оруулснаар нийт зарлагын дээд хэмжээ 3202,2 сая төгрөгөөр батлагдсан байна. Гүйцэтгэлээр 3049,7 сая төгрөгийг зарцуулан 152,5 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гарсан байна. Энэ нь ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрээр гүйцэтгэх төсөл хөтөлбөр 52,4 сая төгрөгөөр дутуу санхүүжсэн, СХС-гийн зээлийн эргэн төлөлтийн 53,0 сая төгрөг төвлөрөөгүйгээс 117,1 сая төгрөгийн зээл төлөвлөснөөс дутуу олгогдсон нь нөлөөлсөн байна.Төсөвт байгууллагууд батлагдсан

төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, зарцуулаагүй үлдэгдлийн ТЗШ-ийн байгууллагууд 16,4 сая, орон нутгийн төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 8,4 сая төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлснээс үзэхэд батлагдсан төсвийг хэтрүүлээгүй байна.

Сумын ЗДТГ-т төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 0,6 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдсанаас бүрэн төвлөрүүлсэн, бусад байгууллагад үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл 3049,7 сая төгрөг буюу 95,2 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсөв захирагчаас болон бусад эх үүсвэрээс 36,3 сая, төсөвт байгууллагын үндсэн бус үйл ажиллагаанаас 13,8 сая, нийт 50,1 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн байна.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 29,2 сая, бусад урсгал шилжүүлгийн зардалд 17,8 сая төгрөгийг тус тус зарцуулан үлдэгдэл 3,1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар нэгтгэсэн тайлангийн хувьд анхаарах асуудал байхгүй болно.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	13	13	10	1	2
2	Хагас жил	3	3	2	1	
3	Улирал бүр	2	8	8	0	
4	Сар бүр	5	60	58	2	
5	Тухай бүр	6	72	71	1	
	Нийт	29	156	149	5	2

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянлиг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянлиг сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дах заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБООС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянлиг сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Орлого төвлөрүүлэлттэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

1. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс тайлант онд 52,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 163,1 сая төгрөгийг зээлд олгохоор төлөвлөсөн боловч 43,0 сая төгрөг төлөгдөж, 39,1 сая төгрөгийн зээл, зээлийн хүү хугацаандаа төлөгдөөгүйгээс төлөвлөсөн хэмжээнд зээл олгогдоогүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг гарахгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх арга хэмжээ авч эх үүсвэрийг бүрдүүлсний дараа зээлийг зохих журмын олгож төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн.

3.2 Хөрөнгө, тооллого тооцоо той холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

1.ТТЗ-чийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 43,3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоогдсоноос 4,2 сая төгрөгийн төлбөрийн акт нь батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсантай, хөрөнгө материалыг орлого аваагүй, хөрөнгийн тооллогыг чанартай хийгээгээс 273,0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгөгдсөн байна.

3.2.2 Эрсдэл:

БНА-2020/10/СТА-ТТЗ

Хөрөнгө үрэгдэх, эзэнгүйдэх, төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

ТТЗ-чийн харьяа байгууллагуудын төсвийн хөрөнгийн зарцуулалт, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах, тооллого тооцоог хугацаанд нь чанартай хийхэд анхаарч, Төсвийн тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил гарсан үр дүнгийн талаар Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 6 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	619506485.66	649488437.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	216044483.09	171880679.89
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	216044483.09	171880679.89
3121	Төгрөг	216044483.09	171880679.89
31211	Төрийн сангийн харилцах	216044483.09	171880679.89
33	АВЛАГА	160461927.98	201348785.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2161053.00	199348.00
335	Бусад авлага	24887999.98	20250000.00
3351	Байгууллагаас авах авлага	11137999.98	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	13750000.00	20250000.00
336	Зээлийн авлага	133412875.00	180899437.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	133412875.00	180899437.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	133412875.00	180899437.00
35	БАРАА МАТЕРИАЛ	241854574.59	276258972.11
351	Түүхий эд материал	22015912.26	33850042.26
35110	Тусгай зориулалттай материал	21400612.26	29113142.26
35130	Эм боох материал	615300.00	4736900.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	38178390.00	34200000.00
354	Хангамжийн материал	166069072.33	192617729.85
35410	Бичиг хэргийн материал	9588400.00	16337080.00

35420	Аж ахуйн материал	138910317.38	143058343.13
35440	Түлш, шатах тослох материал	430.62	0.02
35460	Хүнсний материал	2001918.20	1783740.20
35470	Бусад хангамжийн материал	15568006.13	31438566.50
35600	Мал амьтад	15591200.00	15591200.00
36	НӨӨЦИЙН БАРАА	1145500.00	0.00
36600	Бусад нөөц	1145500.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14045027972.63	13835806016.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14045027972.63	13835806016.14
392	Биет хөрөнгө	13896796939.34	13689012482.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	13954627586.55	14002656764.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	-838218371.99	-1330040588.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	278798402.00	372750162.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-141746747.12	-165618739.45
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	685951767.92	764330646.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	-437069971.50	-434897604.07
